



MONGOLBANK
CENTRAL BANK OF MONGOLIA

Цахим мөрийтэй тоглоомын хууль эрх зүйн зохицуулалт нь мөнгө угаах эрсдэл, эдийн засгийн тогтвортой байдалд хэрхэн нөлөөлж байна вэ?

Санхүүгийн мэдээллийн албаны нэрэмжит эрдэм шинжилгээний бага хурал

УДИРДСАН БАГШ

Э. Тамир /Ph.D/

ОЮУТНЫ НЭР

Н. Эгшиглэн
Д. Болорчимэг
Б. Мөнхзул

АГУУЛГА



Судалгааны удиртгал




Судлагдсан байдлын судалгаа



Судалгааны арга зүй




Шинжилгээний үр дүн




Дүгнэлт, санал зөвлөмж

Судалгааны удиртгал

Интернет хэрэглэгчдийн тоо
/хүн амд эзлэх хувиар/



Цахим мөрийтэй тоглоомын орлогын
хэмжээ /сая доллар/



Эх сурвалж. Дэлхийн Банк

Эх сурвалж. Statista



Судалгааны зорилго, зорилт

Цахим мөрийтэй тоглоомын тархалт болон түүнийг даган гарч буй мөнгө угаах гэмт хэргийн хамаарлыг судлан, эдийн засагт үзүүлэх нөлөөг эдийн засгийн эконометрик шинжилгээний аргаар үнэлэх

- Цахим мөрийтэй тоглоомын хөгжлийн чиг хандлага, зах зээлийн цар хүрээ, хэрэглээний түвшнийг дэлхийн болон бүс нутгийн түвшинд судлах
- Мөнгө угаах үйл ажиллагаанд цахим мөрийтэй тоглоом хэрхэн ашиглагдаж буй механизмыг тодорхойлох
- Цахим мөрийтэй тоглоом болон мөнгө угаах гэмт хэргийн уялдаа холбоог онолын болон олон улсын судалгаанд тулгуурлан задлан шинжлэх
- Цахим мөрийтэй тоглоомоос үүдэлтэй мөнгө угаалтын эрсдэлийн улс орнуудын эдийн засагт үзүүлэх боломжит нөлөөг эконометрик шинжилгээний аргаар үнэлэх
- Таамаглал дэвшүүлэн эконометрик үнэлгээний загвараар тайлбарлах.



Онол ба хэрэглээ

Мөнгө угаах 3 үе шат



Мөрийтэй тоглоомоор дамжуулан мөнгө угаах механизм



Эх сурвалж: Fiedler, I. (2013). Online gambling as a game changer to money laundering



Судлагдсан байдлын судалгаа

Мөнгө угаах эрсдэл ба механизм

Мөрийтэй тоглоом = Мөнгө угаах эрсдэл

- Бэлэн мөнгө давамгайлсан орчин

Хамгийн түгээмэл аргууд (FATF, 2009):

- Их хэмжээний бооцоо → “хожил” мэт бүртгэл
- Чип худалдан аваад буцааж мөнгө болгох
- Цахим тоглоом → олон улсын хуулийн зөрүү ашиглах

Эрсдэлийг нэмэгдүүлдэг хүчин зүйлс (Unger & Ferwerda, 2011):

- KYC сул, Хууль, хяналт сул
- Олон улсын хамтын ажиллагаа муу

Зохицуулалт

- KYC, STR, AML стандартууд хэрэгжсэн улсад эрсдэл буурч байна. (FATF, 2020; Egmont Group, 2021)
- Ил тод байдал = Эдийн засгийн өгөөж + Гэмт хэргээс сэргийлэлт

Цахим мөрийтэй тоглоомын хууль эрх зүйн зохицуулалт

Монгол Улсын нөхцөл байдал

- “Мөрийтэй тоглоомын тухай хууль” (2005) нь цахим орчны зохицуулалтгүй
- Цахим мөрийтэй тоглоомын тодорхойлолт, хяналтын журам, KYC/AML шаардлага, гадаад платформын хандалтыг тусгаагүй
- Энэ нь хууль бус үйл ажиллагаанд орон зай үүсгэж байна.

Олон улсын чиг хандлага

FATF (2019): Цахим мөрийтэй тоглоом бол мөнгө угаах өндөр эрсдэлтэй салбар

- KYC/AML заавал хэрэгжүүлэх
- FIU-д сэжигтэй гүйлгээг мэдээлэх
- Криптовалют, P2P шилжүүлэгт хяналт тавих
- Олон улсын хамтын ажиллагааг сайжруулах



Судлагдсан байдлын судалгаа

Мөрийтэй тоглоомын эдийн засгийн нөлөө

Сөрөг нөлөө:

- Хууль бус мөрийтэй тоглоом → мөнгө угаах, авлига, татварын алдагдал
- Зохицуулалт сул бол өр, гэмт хэрэг нэмэгддэг (Walker & Jackson, 2011)
- Сүүдрийн эдийн засаг өрхийн орлого багатай бүсэд давамгайлдаг (Medda & Parenti, 2022)

Эерэг нөлөө:

- Зохицуулсан орчинд улсын төсөвт орлого нэмэгдэнэ
- АНУ-д хууль ёсны спортын бооцоо жилд 22.4 тэрбум ам.долларын орлого бүрдүүлж, технологи, спорт, маркетингийн салбарт өсөлт авчирсан (Marchi & Jake, 2020)
- ДНБ, ажлын байр, ивээн тэтгэгчийн тоо нэмэгдсэн (Ardeljan, 2023)

Мөрийтэй тоглоомын эдийн засгийн нөлөө

Antwi, Osei-Assibey (2023) нарын “Anti-money laundering measures and financial sector development” судалгаанд дараах хувьсагчдыг ашиглаж, Африкийн 40 орон дээр динамик панел өгөгдлийн шинжилгээ хийсэн:

$$FSD_{it} = \beta_0 + \beta_1 FSD_{i,t-1} + \beta_2 AML_{it} + \beta_3 CPI_{it} + \beta_4 UMP_{it} + \beta_5 UMP_{it} + \beta_6 BRW_{it}$$

FSD – Санхүүгийн салбарын хөгжлийн түвшин

FSD_{t-1} – Санхүүгийн хөгжлийн өмнөх үеийн утга

AML – Мөнгө угаахтай тэмцэх индекс

CPI – Хэрэглээний үнийн индекс

UMP – Ажилгүйдлийн түвшин

BSZ – Банкны хэмжээ (банкуудын зээл / ДНБ)

BRW – Гадаад зээллэгийн хэмжээ



Судалгааны арга зүй

Судалгааны түүвэр бүрдүүлэлт

164



Эх олонлог

136



Цуглуулсан
өгөгдлийн хэмжээ



Судалгааны арга зүй

Судалгааны хувьсагчид

Үзүүлэлт	Хугацаан цуваа	Үзүүлэлт	Хугацаан цуваа
Basel AML Index	2012-2024	Хууль хэрэгжилт	2012-2024
Хэрэглээний үнийн индекс	2012-2024	Гадаадын шууд хөрөнгө оруулалт	2012-2023
Авлигын төсөөллийн индекс	2012-2024	Тэгшитгэл-2	
Дотоодын нийт бүтээгдэхүүн	2012-2024	Цахим мөрийтэй тоглоомын орлого	2020-2024
Хүний хөгжлийн индекс	2012-2022	Мөрийтэй тоглоомын орлого	2020-2024
Хүн ам	2012-2024	Интернэт хэрэглэгчдийн тоо	2020-2024


Эх сурвалж. Судлаачдын нэгтгэлээр



Дэвшүүлсэн таамаглал

H1	AML болон LAW
	Мөрийтэй тоглоомыг хуулиар зохицуулах нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн индекстэй сөрөг хамааралтай
H2	HDI болон AML
	Хүний хөгжлийн индексийн түвшин нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн индекстэй сөрөг хамааралтай

H3	CORRUP болон AML
	Улсын авлигын түвшин нь мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн индекстэй эерэг хамааралтай.
H4	LAW болон GDP
	Мөрийтэй тоглоомыг хуулиар зохицуулах нь тухайн улсын орлого, дотоодын нийт бүтээгдэхүүнд эерэг нөлөө үзүүлнэ.
H5	Internet users болон Revenue
	Улсын интернэт хэрэглэгчдийн тоо өсөх тусам цахим мөрийтэй тоглоомоос орж ирэх орлого нэмэгдэнэ.



Судалгааны арга зүй

Судалгааны загвар

Тэгшитгэл-1 Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн индексийг тайлбарлах

$$AML = \beta_0 + \beta_1 \cdot CPI + \beta_2 \cdot GDP + \beta_3 \cdot HDI + \beta_4 \cdot Population + \beta_5 \cdot Law \\ + \beta_6 \cdot FDI + \beta_7 \cdot Corruption Perceptions Index$$

Тэгшитгэл-2 Цахим мөрийтэй тоглоомын орлогыг түүнд нөлөөлөх хүчин зүйлсээр тайлбарлах

$$Online = \beta_0 + \beta_1 \cdot AML + \beta_2 \cdot GDP + \beta_3 \cdot LAW + \beta_4 \cdot internet_users + \beta_5 \cdot Total$$



Шинжилгээний үр дүн

Регрессийн шинжилгээ

Тэгшитгэл-1 Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн индексийг тайлбарлах

$$AML = 3.7757 - 0.005 \cdot CPI + 6.19 \cdot 10^{-8} \cdot GDP - 4.89 \cdot HDI - 5.31 \cdot 10^{-10} \cdot Population \\ - 0.2118 \cdot Law + 0.0001 \cdot FDI - 0.0155 \cdot Corruption Perceptions Index$$

Тэгшитгэл-2 Цахим мөрийтэй тоглоомын орлогыг түүнд нөлөөлөх хүчин зүйлсээр тайлбарлах

$$Online = 2241.93 - 444 \cdot AML - 0.0005 \cdot GDP - 104.14 \cdot LAW + 2.21 \cdot 10^{-5} \\ \cdot internet_users + 0.2560 \cdot Total$$



Шинжилгээний үр дүн

Хувьсагчдын ерөнхий үзүүлэлтүүд

	Mean	Median	Maximum	Minimum	Std.dev
AML	5.64	5.53	8.60	1.08	1.24
CPI	144.26	120.81	1,660.74	97.75	79.43
GDP	\$ 590,528.7M	\$ 662,223M	\$ 26,006,900M	\$ 93M	2.168
HDI	0.74	0.77	1.00	0.35	0.15
FDI	6.32	2.82	452.22	-440.13	31.68
Population	51,672,921	10,181,976	1,475,000,000	99,543	172,000,000
Corruption Perceptions index	47.13	41.00	92.00	15.00	18.82

Эх сурвалж. Судаачдын тооцоолол



Шинжилгээний үр дүн

Корреляцийн шинжилгээ

	AML	CPI	GDP	HDI	Population	Law	FDI	Corrup
AML	1							
CPI	0.149	1						
GDP	-0.087	-0.070	1					
HDI	-0.746	-0.230	0.185	1				
Population	0.059	0.017	0.550	-0.086	1			
Law	-0.162	0.022	0.024	0.094	-0.048	1		
FDI	-0.034	-0.047	-0.035	0.052	-0.038	0.007	1	
Corrup	-0.657	-0.256	0.191	0.751	-0.077	0.108	0.032	1

Эх сурвалж. Судлаачдын тооцоолол



Шинжилгээний үр дүн

№	Таамаглал	Төлөв
1	Мөрийтэй тоглоомыг хуулиар зохицуулах нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн индекстэй сөрөг хамааралтай.	Батлагдсан
2	Хүний хөгжлийн индексийн түвшин нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн индекстэй (AML) сөрөг хамааралтай.	Батлагдсан
3	Улсын авлигын түвшин нь мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн индекстэй эерэг хамааралтай.	Батлагдсан
4	Мөрийтэй тоглоомыг хуулиар зохицуулах нь тухайн улсын орлого, дотоодын нийт бүтээгдэхүүнд эерэг нөлөө үзүүлнэ.	Батлагдсан
5	Улсын интернэт хэрэглэгчдийн тоо өсөх тусам цахим мөрийтэй тоглоомоос орж ирэх орлого нэмэгдэнэ	Батлагдсан

Эх сурвалж. Судлаачдын эмхэтгэл



Дүгнэлт

Энэхүү судалгааны ажил нь цахим мөрийтэй тоглоомын тархалт, түүнтэй холбоотой мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлд нөлөөлөгч хүчин зүйлсийг 136 улсын мэдээлэлд суурилан шинжиллээ. Уг судалгааны ажлын онцлог нь өмнөх судалгааны ажлуудтай харьцуулахад зөвхөн AML индексэд үзүүлэх нөлөөллийг судлахаас гадна цахим мөрийтэй тоглоомын орлогын хэмжээг хамааран хувьсагч болгон авч үзсэнд оршино.

- Хууль эрх зүйн зохицуулалт нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг (AML) бууруулах хүчин зүйл болохыг илтгэж байна.
- Хүний хөгжлийн индекс (HDI) нь мөн AML индекстэй хамгийн хүчтэй сөрөг хамааралтай гарсан нь боловсрол, орлогын түвшин, амьдралын чанар зэрэг үзүүлэлтүүд мөнгө угаахтай тэмцэх суурь хүчин зүйл болохыг харуулж байна.
- Мөн авлигын төсөөллийн индексийн коэффициент сөрөг сул хамааралтай гарсан нь бодит тоон үзүүлэлт дээр үндэслэн авлигын түвшин буурах тусам мөнгө угаахтай холбоотой эрсдэл буурах хандлагатай болохыг баталж байна.
- Интернэт хэрэглэгчдийн тоо нь цахим мөрийтэй тоглоомын орлоготой шууд хамааралтай бөгөөд энэ нь дижитал орчны хөгжил, дэд бүтцийн өсөлт нь цахим мөрийтэй тоглоомын эдийн засаг дахь оролцоог нэмэгдүүлж байгааг илтгэж байна.



Дүгнэлт

- Цахим мөрийтэй тоглоомын орлогын регрессийн шинжилгээгээр хууль эрх зүйн зохицуулалт нэмэгдэхийн хэрээр тус төрлийн орлого буурах магадлалтай байгааг харуулсан хэдий ч, цахим мөрийтэй тоглоомын зохицуулагдсан орчин болон улсын эдийн засгийн үзүүлэлт болох ДНБ-ий хооронд эерэг хамааралтай. Энэ нь хуульчилсан, зохистой хяналт бүхий тогтолцоо нь цахим мөрийтэй тоглоомоос орж ирэх эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх боломжтойг илтгэж байна.
- Эдгээр үр дүн нь зөвхөн гэмт хэрэг бууруулах төдийгүй эдийн засгийн өсөлтийг дэмжих боломжийг ч харуулж байна.

Санал зөвлөмж

- Цаашид хууль эрх зүйн ил тод байдал, хэрэглэгчийг таних (KYC) стандартын нэвтрэлт, хяналт шалгалтын механизм, хууль сахиулах байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах нь зөвхөн гэмт хэрэгтэй тэмцэх бус, эдийн засгийн тогтвортой өсөлтийг нэмэгдүүлэх боломжтой.
- Иймд цахим мөрийтэй тоглоомын хууль эрх зүйн зохицуулалтгүй улс орнууд энэ чиглэлд оновчтой бодлого боловсруулж, хэрэгжилтийн чанарыг өндөр түвшинд хангах нь зүйтэй.
- Иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, цахим мөрийтэй тоглоомын эрсдэлийг ойлгуулах сургалт, мэдээлэл түгээх ажилд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх хэрэгтэй.



Ном зүй

- Antwi, S. T. (2023). Anti-money laundering measures and financial sector development: Empirical evidence from Africa.
- Ardeljan. (2023). Impact of Sports Gambling Legality on U.S. States' Real GDP per Capita.
- Borgy, V., Clerc, L., & Renne, J. (2009). Asset-price boom-bust cycles and credit: What is the scope of macro-prudential regulation? Banque de France Working Paper No. 263.
- Borio, C. (2003, February). Towards a macroprudential framework for financial supervision and regulation? BIS Working Paper No. 128.
- Douglas M. Walker, & Jackson, J. D. (2011). The Effect of Legalized Gambling on State Government Revenue.
- FATF. (2009). Vulnerabilities of Casinos and Gaming Sector.
- FATF. (2020). Money Laundering and Terrorist Financing Risks.
- FATF. (2022). Annual Report
- Marchi, J. (2020). The Economic Impact of Legalized Sports Gambling.
- Medda, G. P. (2022). Illegal Gambling: Measuring the Market Using the MIMIC Model.
- Ramirez, J. (2018). Determinants of money laundering: Evidence from Italian regions.
- Richard A. McGowan, & Rehm, J. (2013). Sports and Internet Gambling: A Friendly Wager or a Threat to the Integrity of the Game?
- Robert J. Williams, & Rehm, J. (2011). The Social and Economic Impacts of Gambling.
- Savona, E. U. (2015). From Illegal Markets to Legitimate Businesses.
- Spitz, D. J., & Terry, R. P. (2020). We Can Handle It: Advocating in Support of State Legislation of Legal Sports Gambling Post-Murphy v. NCAA.
- Statista. (2022). Gambling Worldwide.
- Financial Action Task Force. (2009). Vulnerabilities of Casinos and Gaming Sector.

**АНХААРЛ
ХАНДУУЛСАНД
БАЯРЛАЛАА**

